



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 88
танай _____ ны № _____ т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020363

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,621,965,418.78	9,852,697,393.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,151,739,268.62	6,748,891,606.96
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,151,739,268.62	6,748,555,606.96
31210	Төгрөг	6,151,739,268.62	6,748,555,606.96
31211	Төрийн сангийн харилцах	1,122,671.98	263,072.00
31213	Арилжааны банк дахь харилцах	6,150,616,596.64	6,748,292,534.96
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	0	336,000.00
33	АВЛАГА	2,452,953,303.10	3,086,936,749.31
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	395,476,599.02	633,151,726.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,966,743,255.59	2,390,415,463.62
33500	Бусад авлага	90,733,448.49	63,369,559.11
33510	Байгууллагаас авах авлага	90,733,448.49	63,369,559.11
35	БАРАА МАТЕРИАЛ	17,272,847.06	16,869,037.30
35400	Хангамжийн материал	17,272,847.06	16,869,037.30
35410	Бичиг хэргийн материал	42,300.00	1,618,800.00
35420	Аж ахуйн материал	13,802,352.00	12,838,862.00
35440	Түлш, шатах тослох материал	1,089,400.00	1,551,900.00
35470	Бусад хангамжийн материал	2,338,795.06	859,475.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,177,221,070.14	1,139,531,065.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,177,221,070.14	1,139,531,065.61
39200	Биет хөрөнгө	1,170,251,070.14	1,130,612,041.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,102,041,952.12	1,102,041,952.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,540,895.79	-62,538,842.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980,000.00	89,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,980,000.00	-89,980,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	143,804,139.38	132,474,604.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,963,855.57	-75,472,807.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,074,400.00	88,558,495.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,164,670.00	-54,451,360.00
39300	Биет бус хөрөнгө	6,970,000.00	8,919,024.50
39301	Програм хангамж	3,666,123.00	2,198,830.75
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,666,123.00	-249,806.25
39303	Бусад биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,799,186,488.92	10,992,228,459.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	187,189,836.09	228,125,660.86
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	187,189,836.09	228,125,660.86
41300	Өглөг	43,532,575.84	51,987,107.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,889.60	13,875.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	42,815,249.77	51,270,795.55
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	577,800.00	577,800.00
41360	Бусад өглөг	124,636.47	124,636.47
41361	Байгууллагад төлөх өглөг	124,636.47	124,636.47
41400	Урьдчилж орсон орлого	143,657,260.25	176,138,553.24
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	143,657,260.25	176,138,553.24

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,611,996,652.83	10,764,102,798.32
51	Засгийн газрын хувь оролцоо	9,611,996,652.83	10,764,102,798.32
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,679,914.75	181,679,914.75
51200	Хуримтлагдсан үр дүн	9,427,610,557.41	10,579,716,702.90
51210	Өмнөх үеийн үр дүн	2,197,524,362.31	9,449,638,538.04
51220	Тайлант үеийн үр дүн	7,230,086,195.10	1,130,078,164.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,706,180.67	2,706,180.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,799,186,488.92	10,992,228,459.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,330,648,878.43	58,308,845,767.47
11	ТАТВАРЫН ОРЛОГО	22,664,561,822.99	22,752,357,918.15
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	22,664,561,822.99	22,752,357,918.15
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	16,989,994,745.28	16,937,913,569.98
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,430,381,544.84	1,403,169,548.91
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	923,200,643.90	858,602,429.79
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	242,952,897.84	251,927,708.85
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,078,031,991.13	3,300,744,660.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,003,533,371.86	53,420,342.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,003,533,371.86	53,420,342.32
120002	Хүүгийн орлого	75,025,482.35	12,635,267.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,257,932.51	34,673,746.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,529,132.51	34,275,546.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	728,800.00	398,200.00
120009	Бусад орлого	600,000.00	583,850.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	913,649,957.00	5,527,478.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,662,553,683.58	35,503,067,507.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	55,800,000.00	0
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	55,800,000.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,783,801.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,783,801.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	35,963,407,682.58	34,874,116,007.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,963,407,682.58	34,874,116,007.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	639,562,200.00	628,666,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	639,562,200.00	628,666,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	53,107,632,215.83	57,188,330,583.28

21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,107,632,215.83	57,188,330,583.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,401,061.03	653,571,200.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448,352,635.00	441,955,727.00
210101	Үндсэн цалин	329,756,261.00	325,192,723.00
210102	Нэмэгдэл	94,348,374.00	91,119,990.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,408,000.00	16,740,000.00
210104	Урамшуулал	6,840,000.00	8,903,014.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,338,994.35	58,024,754.74
210201	Тэтгэврийн даатгал	37,713,322.81	40,147,327.81
210202	Тэтгэмжийн даатгал	4,659,234.83	4,467,906.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,724,007.53	3,574,324.89
210204	Ажилгүйдлийн даатгал	929,593.41	893,581.22
210205	Эрүүл мэндийн даатгал	9,312,835.77	8,941,614.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,004,411.10	32,685,264.87
210301	Гэрэл, цахилгаан	2,657,520.10	2,022,074.07
210302	Түлш, халаалт	28,181,256.00	27,567,838.80
210303	Цэвэр, бохир ус	2,165,635.00	3,095,352.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,162,016.64	22,883,893.00
210401	Бичиг хэрэг	5,401,010.00	5,254,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,618,200.00	9,244,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,074,586.64	3,735,510.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,018,220.00	4,549,383.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,322,750.00	7,623,099.04
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,685,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	6,637,750.00	6,123,099.04
2107	Томилолт, зочны зардал	2,492,800.00	634,000.00
210702	Дотоод албан томилолт	2,492,800.00	634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,046,575.72	24,140,021.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,658,289.92	14,442,978.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.00	654,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	56,100.00
210807	Газрын төлбөр	21,705.00	30,392.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,720,890.00	6,474,620.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,549,590.80	2,481,481.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,680,878.22	65,624,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,936,600.00	2,018,290.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,744,278.22	63,606,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,442,231,154.80	56,534,759,382.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,559,015,133.00	52,711,125,714.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	48,543,999,932.00	52,702,684,254.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,687,500.00	8,441,460.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,829,900.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	497,801.00	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,883,216,021.80	3,823,633,668.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,883,216,021.80	3,823,633,668.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,223,016,662.60	1,120,515,184.19
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,291,470.83	9,562,980.67
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	7,291,470.83	9,562,980.67
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	221,938.33	0
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	221,938.33	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,230,086,195.10	1,130,078,164.86

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	2,134,060,383.09	2,318,446,478.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	63,463,979.22	63,463,979.22
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	2,197,524,362.31	2,381,910,457.73
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	7,230,086,195.10	7,230,086,195.10
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	9,427,610,557.41	9,611,996,652.83

11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	9,427,610,557.41	9,611,996,652.83
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	22,185,480.63	22,185,480.63
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	9,449,796,038.04	9,634,182,133.46
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,130,078,164.86	1,130,078,164.86
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	10,579,716,702.90	10,764,102,798.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	57,531,646,410.97	57,922,587,571.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20,809,669,073.33	22,102,822,477.79
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	20,809,669,073.33	22,102,822,477.79
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,501,165,105.34	16,584,618,331.40
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,249,144,123.80	1,269,711,871.53
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	765,395,768.48	750,271,745.87
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	218,507,382.47	230,376,190.47
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,075,456,693.24	3,267,844,338.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,076,336.64	303,628,593.46
120	Нийтлэг татварын бус орлого	175,076,336.64	303,628,593.46
120002	Хүүгийн орлого	75,025,482.35	12,635,267.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,050,854.29	290,993,326.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,322,054.29	290,595,126.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	728,800.00	398,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,546,901,001.00	35,516,136,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	25,185,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	25,185,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,783,801.00	285,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,783,801.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	35,903,555,000.00	34,862,000,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,903,555,000.00	34,862,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	639,562,200.00	628,666,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	639,562,200.00	628,666,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,106,082,441.58	57,325,435,232.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,106,082,441.58	57,325,435,232.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,911,283.01	588,595,793.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448,352,636.00	441,956,741.00
210101	Үндсэн цалин	342,047,838.00	333,187,357.00
210102	Нэмэгдэл	80,780,567.00	86,662,333.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,167,493.00	15,285,586.00
210104	Урамшуулал	10,356,738.00	6,821,465.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,338,994.35	58,024,754.74
210201	Тэтгэврийн даатгал	37,713,322.81	40,147,327.81
210202	Тэтгэмжийн даатгал	4,659,234.83	4,467,906.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,724,007.53	3,574,324.89
210204	Ажилгүйдлийн даатгал	929,593.41	893,581.22
210205	Эрүүл мэндийн даатгал	9,312,835.77	8,941,614.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,004,411.10	32,685,264.87
210301	Гэрэл, цахилгаан	2,657,520.10	2,022,074.07
210302	Түлш, халаалт	28,181,256.00	27,567,838.80
210303	Цэвэр, бохир ус	2,165,635.00	3,095,352.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,966,106.64	23,959,403.00
210401	Бичиг хэрэг	5,435,310.00	6,831,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,707,600.00	9,706,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,074,586.64	3,735,510.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,698,610.00	3,585,893.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,322,750.00	7,623,099.04
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,685,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	6,637,750.00	6,123,099.04
2107	Томилолт, зочны зардал	2,492,800.00	634,000.00
210702	Дотоод албан томилолт	2,492,800.00	634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,496,984.92	21,694,240.63

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,658,289.92	14,442,978.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.00	654,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	56,100.00
210807	Газрын төлбөр	21,705.00	30,392.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,720,890.00	6,474,620.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0	35,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,936,600.00	2,018,290.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,936,600.00	2,018,290.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,503,171,158.57	56,736,839,439.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,619,955,136.77	52,913,493,930.39
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	48,545,783,550.04	52,709,874,839.02
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,687,500.00	8,441,460.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,156,385.73	195,177,631.37
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,829,900.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	497,801.00	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,883,216,021.80	3,823,345,509.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,883,216,021.80	3,823,345,509.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,425,563,969.39	597,152,338.34
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,425,563,969.39	597,152,338.34
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,726,175,299.23	6,151,739,268.62
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,151,739,268.62	6,748,891,606.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,501,371,900.00	53,305,618,392.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,501,371,900.00	53,305,618,392.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,949,200.00	588,275,093.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,098,000.00	441,956,741.00
210101	Үндсэн цалин	355,277,400.00	333,187,357.00
210102	Нэмэгдэл	83,459,000.00	86,662,333.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,521,600.00	15,285,586.00
210104	Урамшуулал	6,840,000.00	6,821,465.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,593,200.00	58,024,754.74
210201	Тэтгэврийн даатгал	41,949,200.00	40,147,327.81

210202	Тэтгэмжийн даатгал	4,661,000.00	4,467,906.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,728,800.00	3,574,324.89
210204	Ажилгүйдлийн даатгал	932,200.00	893,581.22
210205	Эрүүл мэндийн даатгал	9,322,000.00	8,941,614.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,500,000.00	32,685,264.87
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,022,074.07
210302	Түлш, халаалт	34,000,000.00	27,567,838.80
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,095,352.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,038,700.00	23,959,403.00
210401	Бичиг хэрэг	6,831,100.00	6,831,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,707,600.00	9,706,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,800,000.00	3,735,510.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	3,585,893.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,623,100.00	7,623,099.04
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	6,123,100.00	6,123,099.04
2107	Томилолт, зочны зардал	661,700.00	634,000.00
210702	Дотоод албан томилолт	661,700.00	634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,434,500.00	21,658,540.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,551,800.00	14,442,978.63
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	654,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	56,100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	30,392.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,932,700.00	6,474,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,733,290.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,733,290.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,873,422,700.00	52,717,343,299.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,873,422,700.00	52,717,343,299.02
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	52,865,922,700.00	52,709,874,839.02
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,468,460.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,501,371,900.00	18,907,026,465.13
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,760,392,800.00	25,185,000.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	8,760,392,800.00	25,185,000.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,740,979,100.00	18,847,476,985.85
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	44,740,979,100.00	18,847,476,985.85
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	34,364,479.28
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	33,966,181.83
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	398,297.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	6,151,739,268.62
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	6,748,891,606.96

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	79	75
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	37
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	32	30
620003	Үйлчлэх ажилтан	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	37
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34	31
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	285,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус хэлтэс Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийгмийн даатгалын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилго, зорилтууд, Аймгийн засаг даргын 2020-2024 онд дэвшүүлсэн “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 37 албан хаагч, үүнээс 16 суманд нийгмийн даатгалын хуулийг орон нутагт хэрэгжүүлэх үйлчилгээг хүргэх 16 байцаагч, үйлчилгээний 2, гэрээт 3, бусад гүйцэтгэх 16 албан хаагчтайгаар төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан ажлаа жил, улирал, сараар төлөвлөн ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 8 зорилт бүхий 43 арга хэмжээг 98,9 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажилласан .

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 998,126.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,971.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,480.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,389.9 мянган төгрөгөөр буюу 7.38 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурсан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцож хассан дүн нөлөөлсөн байна. Бараа материалын дүн өссөн нь зарцуулалт худалдан авалтаас бага байгаатай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,151,739.3	6,748,891.6	597,152.3
Авлага	2,452,953.3	3,086,936.8	633,983.5
Бараа материал	17,272.8	16,869.0	(403.8)
Үндсэн хөрөнгө	1,177,221.1	1,139,531.1	(37,690.0)
Нийт хөрөнгө	9,799,186.5	10,992,288.5	1,193,042.0
Өглөг	43,532.6	51,987.1	8,454.5
Урьдчилж орсон орлого	143,657.3	176,138.6	32,481.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,611,996.6	10,764,102.8	1,152,106.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,799,186.5	10,992,288.5	1,193,042.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,635.3 мянган төгрөгийн хүүгийн орлогыг арилжааны банкнаас харилцах дансны үлдэгдэл бодож олгосон. 34,275.6 мянган төгрөг үндсэн үйл ажиллагааны орлого, 398.2 мянган төгрөг туслах үйл ажиллагааны , 583.8 мянган төгрөг бусад орлого орсон байна. 695,625.9 мянган төгрөгийг хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардал төсвийн санхүүжилтээр зарцуулсан, тэтгэвэр тэтгэмж, НД-ийн бусад үйл ажиллагаанд 56,492,704.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангийн арилжааны банкин дахь харилцах дансны нийт үлдэгдэл 6,748,741.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба Төрийн банк дахь үлдэгдэл 1,996,807.8, Төрийн сангийн үлдэгдэл 113,400.02 мянган төгрөг, Хаан банк дахь үлдэгдэл 4,751,484.5 мянган төгрөг, үйл ажиллагааны харилцах дансанд 149.8 мянган төгрөг үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 3,086,711.0 мянган төгрөгийн НДШ-ийн болон НДШ-ийг төрөөс чөлөөлсөн чөлөөлөлт, ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн авлагатай ба үйл ажиллагааны тайланд 225.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хангамжийн материалын үлдэгдэл 16,869.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүйл байгаа ба үүнээс 1,618.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 12,838.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1,551.9 мянган төгрөгийн шатахуун, 16,009.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 859.5 мянган төгрөгийн маягтын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,139,531.1 мянган төгрөг болж 37,690.0 мянган төгрөгөөр буурсан тайлан хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Мөн тайлант хугацаанд ковидын нөхцөл байдлаас шалтгаалж цахим хурал байнга зохион байгуулах болсон тул хуралд ашиглагдах 899,0 мянган төгрөгийн Таб худалдан авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 227,409.4 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр байгаагийн 47,709.9 мянган төгрөгийн өр төлбөр жилийн эцэст андуурсан гүйлгээ орж ирсэн, 40,031.4 мянган төгрөг нь илүү төлсөн НДШ, сайн дурын даатгалын илүү төлөлт 124657.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын илүү төлөлт 11,449.2 мянган төгрөг, 3561.3 мянган төгрөгийн тэтгэмжийн дутуу олголт байна. Сангийн 51270.8 мянган төгрөг нь жилийн эцэст данс андуурч ташаарсан гүйлгээ орж ирсэн ба үйл ажиллагааны 716.3 төгрөг, ажилчдад өгөх өглөг 13.9 мянган төгрөг, хөрөнгө бэлтгэхтэй холбогдон үүссэн 577.8 мянган төгрөг бусад байгууллагад өгөх 124.6 мянган төгрөгийн өглөг байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл сайн дурын даатгалын болон байгууллагуудын илүү төлсөн шимтгэлийн орлого, мөн хүүхдээ 0-3 нас хүртэл асарч буй эхчүүдийн илүү төлсөн НДШ-ийн төлбөрөөс бүрдэж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,764.1 мянган төгрөг болж 1,152,106.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 2,021,803.1 мянган төгрөгөөр буюу 3,4 хувиар, нийт зардал өмнөх оноос 4,080,698.4 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг Нийгмийн даатгалын хэлтэс нь тайлант нийгмийн даатгалын сангийн 22,799,852.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт үйл ажиллагааны зарлагыг 3 34,884,831.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын хүргүүлсэн төсвийн төслийн хүрээнд орлогыг 45,290.0 мянган төгрөгөөр бууруулан 22,754,562.5 мянган төгрөгөөр орлогыг бүрдүүлэхээр, үйл ажиллагааны зарлагыг 10,265.3 мянган төгрөгөөр бууруулан 34,874,116.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөр 89 арга хэмжээг санхүүжүүлэхээр, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 22,752,357.9 мянган төгрөг, өөрийн орлогоос 34,673.7 мянган төгрөг, хүүгийн орлого 12,635.3 мянган төгрөг, тусламж санхүүжилтийн орлогоос 35,503,067.5 мянган төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 53,305,618.4 мянган төгрөгийг зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 53,305,618.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлаас 24,141.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын зардлаас 2,568.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 7,814.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 79.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 4,776.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 285.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс 285.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардал зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын ажилчдын 1 415.3 мянган төгрөгийн ХЧТА-ын тэтгэмжийн материалыг 6, 7-р сард бүрдүүлэн өгсөн боловч Нийгмийн даатгалын байцаагчийн буруугаас хугацаа хоцроосон боловч хариуцлага тооцогдоогүй 9-р сард нийгмийн даатгалын сангаас олгосон байна. Энэ нь МУ-ын улсын хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/30 тоот тушаалаар батлагдсан журмын 6.1, Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн нь эргүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, нийгмийн даатгалын тухай хуулийн заалт болон захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ" заалтыг зөрчсөн байна.

Түүвэрлэн шалгахад харилцахаас олгосон 9-р сарын ХЧТА-ын жагсаалттай анхан шатны бүрдүүлсэн материалууд таарахгүй зарим материалууд үдэгдээгүй, баримтын бүрдэл дутуу байна. ЖАТ, ХЧТА-ын тэтгэмж олгохдоо анхан шатны баримтын дүн зөрүүтэй нэхэмжлэхийн дүнг тооцоолсон дүнгээр засуулдаггүй, тэтгэмж олгох материалыг цахимаар хянаж хүлээн авсан ч хуулбарыг баримт үдэхдээ эх хувь болгон хавсаргадаггүй. Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй сүүлийн жилүүдэд дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 163 дугаар тушаалаар батлагдсан Тэтгэвэр тэтгэмж тогтооход шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэх, хянах журмын 4.2.3. "Нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ нь тухайн ажил олгогчоос ирүүлсэн нэхэмжлэл, эмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж олгосон жагсаалт /НД№35, 36/-ыг хянан баталгаажуулж, хэлтсийн нэгдсэн мэдээлэлд оруулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бодлогын баримт бичгийн дансны төлөвлөгөөний дагуу зардлыг тайлагнаагүй нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 80.0 мянган төгрөгийн машин засварын мөнгийг урсгал зардалд, шуудан холбооны зардлаас 154.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн зардлыг төлж шуудан холбооны зардалд тайлагнасан байна. Энэ нь МУ-ын Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалын дагуу "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу тайлагнаж бүртгэх, мөн төсвийн тухай хуулийн 22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 онд 630,055.6 мянган төгрөгийн 160 мэдээллийг ил тод байршуулахаас 2 мэдээлэл мэдээлэх хугацаа болоогүй, 630,055.6 мянган төгрөгийн 158 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн. Тайлангийн хугацааны эцэст үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийх хэлтсийн даргын тушаал гарсан боловч жилийн эцсийн тооллогоор шатахууны 1 551.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө гэсэн заалтын дагуу хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодож байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Мөн групптэй ажилтны амралтыг бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 315,059.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 946.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 47,011.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 247,101.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг 90 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/ Мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	946.1	2	946.1			
Албан шаардлага	5	47,011.6	5	47,011.6	-	-	
Зөвлөмж	4	247,101.4	4	247,101.4	1	-	10
Нийт дүн	11	315,059.1	11	315,059.1	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар, орсон санхүүжилтээр гарсан зардал тухай бүрд нь тайлагнаагүй бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс дансанд тайлагнаж байна. Цаашид зардлыг Сангийн сайдын

2021 оны 190 тушаалаар батлагдсан “ Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар ” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай. Мөн Булган аймгийн нийгмийн даатгалын сангийн баримтанд сорил гүйцэтгэхэд нийгмийн даатгалын сангаас олгогдож байгаа тэтгэмжүүдийн материалуудыг хамтад нь хольж, банк тус бүрээр үдээгүй бүх банкийг хольж үдсэн. Үдсэн баримтууд нүүрлэлт, товъёог дугаарлалт байхгүй эмх цэгцгүй хөл толгойг уруу харуулан үдсэн зэргээр архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулийн шаардлага хангахгүй байгаа тул цаашид анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,753.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 120.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 6,406.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 4,227.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Акт

Илрүүлэлт:

120.0 мянган төгрөгийн томилолт, 40 мянган төгрөгийн шатахууны гүйлгээнд хувь хүний сугалаатай баримт хавсаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт хүргүүлэв.

Өгсөн акт: Анхан шатны баримтын иж бүрэн байдлыг хангах.

4.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст нийт 5,007.3 мянган төгрөгийн гүйлгээ е баримтгүй анхан шатны баримтын бүрдэлгүй хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.

1.2. Өгсөн албан шаардлага:

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

2.1 Илрүүлэлт:

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй 500.0 мянган төгрөгийн шагнал урамшууллын мөнгө олгосон 899.0 мянган төгрөгийн таб худалдан авч хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6, 1.3 дахь заалтын хүрээнд зардал гаргахгүй байх заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн албан шаардлага:

Тайлант хугацаанд гарсан хууль тогтоомжийг судалж, хэрэгжүүлж ажиллах.

3.1 Илрүүлэлт:

Булган аймгийн нийгмийн даатгалын сангийн баримтанд сорил гүйцэтгэхэд нийгмийн даатгалын сангаас олгогдож байгаа тэтгэмжүүдийн материалуудыг хамтад нь хольж, банк тус бүрээр үдээгүй бүх банкийг хольж үдсэн. Үдсэн баримтууд нүүрлэлт, товьёог дугаарлалт байхгүй эмх цэгцгүй хөл толгойг уруу харуулан үдсэн зэргээр архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулийн шаардлага хангахгүй байна.

3.2 Өгсөн албан шаардлага:

Нийгмийн даатгалын Сангийн бичиг баримтыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 заалтын 35.4.1.байгууллагын үйл ажиллагааг холбогдох журам, стандартын дагуу баримтжуулах; 35.4.2.баримт бичгийг боловсруулахад Монгол хэлний тухай хуулийн 8.1-д заасны дагуу монгол хэлний зөв бичих дүрмийг мөрдөх; 35.4.3.баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах; 35.4.4.хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг төрөлжүүлэн ангилах; 35.4.5.баримт бичиг хянан шийдвэрлэхэд холбогдох хууль, журамд заасан хугацааг баримтлах; 35.4.6.албан ажил үүрэгтэй холбогдсон баримт бичиг, мэдээллийн нууцлалыг хадгалах;

35.4.7.баримт бичгийг байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх зэрэг заалтуудыг баримтлан ажиллах.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлангийн хугацаанд ажилчдын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлтийг 59.7 мянган төгрөгөөр дутуу тооцож 67.5 мянган төгрөгөөр илүү тооцон тайлагнасан байна.Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ: гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Цалингийн бодолтыг жилийн эцсээр тулган татварын тайланг залруулаж зөв бодож байх.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийх хэлтсийн даргын тушаал гарсан боловч жилийн эцсийн тооллогоор шатахууны 1,551.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө гэсэн заалтын дагуу хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодож байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Тооллогыг үнэн зөв бодитой хийж байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Групптэй ажилтны амралтыг бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн

заалтаар амралтын хоногийг нэмж биеэр амрааж амралтын мөнгийг тооцож олгох гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Ажилчдын амралтын хоногийг зөв тооцож олгож байх

4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Дотоод журманд заагдсан ажилчдад олгодог шинэ хүүхэд төрсөн болон төрөл төрөгсөд нь нас барсан үед өгсөн 462.3 мянган төгрөгийн тусламж тэтгэмжээс ХХОАТ тооцоогүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж; гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Хувь хүнээс авч байгаа ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо холбогдох хуулиудын дагуу шимтгэл, татварыг тооцож олгож байх

5. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Бодлогын баримт бичгийн дансны төлөвлөгөөний дагуу зардлыг тайлагнаагүй нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 80.0 мянган төгрөгийн машин засварын мөнгийг урсгал зардалд, шуудан холбооны зардлаас 154.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн зардлыг төлж шуудан холбооны зардалд тайлагнасан байна. Энэ нь Му-ын Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалын дагуу Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу тайлагнаж бүртгэх, мөн төсвийн тухай хуулийн 22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

МУ-ын Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалын дагуу Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу тайлагнаж бүртгэх.

6. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Түүвэрлэн шалгахад харилцахаас олгосон 9-н сарын ХЧТА-ын жагсаалттай анхан шатны бүрдүүлсэн материалууд таарахгүй зарим материалууд үдэгдээгүй баримтын бүрдэл дутуу байна. ЖАТ, ХЧТА-ын тэтгэмж олгохдоо анхан шатны баримтын дүн зөрүүтэй нэхэмжлэхийн дүнг тооцоолсон дүнгээр засуулдаггүй, тэтгэмж олгох материалыг цахимаар хянаж хүлээн авсан ч хуулбарыг баримт үдэхдээ эх хувь болгон хавсаргадаггүй. Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй сүүлийн жилүүдэд дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 163 тушаалаар батлагдсан Тэтгэвэр тэтгэмж тогтооход шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэх, хянах журмын 4.2.3. Нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ нь тухайн ажил олгогчоос ирүүлсэн нэхэмжлэл, эмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж олгосон жагсаалт /НД№35, 36/-ыг хянан баталгаажуулж, хэлтсийн нэгдсэн мэдээлэлд оруулна. Хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч энэхүү хянаж баталгаажуулсан баримтыг шалгасны үндсэн дээр уг тэтгэмжийг нийгмийн даатгалын холбогдох сангаас ажил олгогчдод шилжүүлж тооцоо хийнэ.

6.2 Өгсөн зөвлөмж:

Хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч энэхүү хянаж баталгаажуулсан баримтыг шалгасны үндсэн дээр уг тэтгэмжийг нийгмийн даатгалын холбогдох сангаас ажил олгогчдод шилжүүлж тооцоо хийж байх.

7. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Баатарван амралт сувиллын ажилчид 1 415.3 мянган төгрөгийн ХЧТА-ын тэтгэмжийн материалыг 6.7 сард бүрдүүлэн өгсөн боловч Нийгмийн даатгалын байцаагчийн буруугаас хугацаа хоцроосон боловч хариуцлага тооцогдоогүй 9 сард нийгмийн даатгалын сангаас олгосон. Энэ нь МУ-ын улсын хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/30 тоот тушаалаар батлагдсан журмын 6.1 Нийгмийн даатгалын тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн нь эргүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, нийгмийн даатгалын тухай хуулийн заалт болон захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ" заалтыг зөрчсөн байна.

7.2 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн даатгалын хэлтэс	11	10,753.8	-	-	1	120.0	3	6,406.3	7	4,227.5
	Дүн	11	10,753.8	-	-	1	120.0	3	6,406.3	7	4,227.5

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Д.АНХБАЯР